



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн  
ГЗ-ийн 2014 оны 10 сарын 17-ны өдрийн  
165 тоот тушаалын хавсралт №1.

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АРИЛЖАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

### Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү зааврын зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид МХБ гэх/ дээр явагдаж буй үнэт цаасны болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулах, арилжааны дэгийг тогтоон мөрдөхөд оршино.
2. Үнэт цаасны арилжааг Арилжааны алба зохион байгуулна.
3. Үнэт цаасны “Арилжааны өдөр” нь дор дурдсан үе шатуудаас бүрдэх бөгөөд дараах цагийн хуваарийн дагуу явагдана. Үүнд:
  - 3.1. Арилжааны өмнөх үе: 09.25 -09.40
  - 3.2. Нээлтийн дуудлага арилжаа: 09.40 -10.00
  - 3.3. Энгийн арилжаа: 10.00 -13.00
  - 3.4. Арилжааны хаалтын үе: 13.00 -13.05
  - 3.5. Хаалтын дараах үе: 13.05 -14.00
4. Энэхүү зааварт орсон нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
  - 4.1. “Арилжаа хөтлөгч” (Market operator) - Үнэт цаасны арилжааг зохион байгуулж явуулах чиг үүрэг бүхий Арилжааны албаны мэргэжилтэн,
  - 4.2. “Арилжааны дэг хянагч” (Trading floor supervisor) - Үнэт цаасны арилжааг хянах чиг үүрэг бүхий хяналт шалгалтын ажилтан,
  - 4.3. “Арилжааны програм хангамжийг хянагч” (Trading software supervisor)- Үнэт цаасны арилжааны үеийн програм хангамж, техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий Мэдээлэл технологийн албаны мэргэжилтэн,
  - 4.4. “Арилжаанд оролцогч” (Securities trading participant) – МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх бүхий гишүүн үнэт цаасны компанийн ажилтан,
  - 4.5. “Алсаас арилжаанд оролцогч” (Remote trading) – Арилжааны програм хангамжийг ашиглан өөрийн ажлын байрнаас арилжаанд оролцож буй, МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх бүхий гишүүн үнэт цаасны компанийн ажилтан,
5. Арилжаанд оролцогч нь арилжааны өдөр зөвхөн 09.40-14.00 цагуудад МХБ-ийн арилжааны системд хандан арилжаанд оролцоно.
6. Алсаас арилжаанд оролцогч нь өөрсдийн ажлын байрнаас арилжаанд оролцох боломжгүй тохиолдолд МХБ-д урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр арилжааны танхимаас арилжаанд оролцож болно.

## Хоёр. Үнэт цаасны арилжааны бэлтгэл ажлыг хангах

7. Үнэт цаасны арилжаа эхлэхээс өмнө *арилжаа хөтлөгч* дараах бэлтгэл ажлуудыг хангана. Үүнд:
  - 7.1. Шаардлагатай тохиолдолд Санхүүгийн Зохицуулах Хороо, Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрээр өмнөх арилжааны өдөр системд бүртгэгдсэн захиалгуудыг өөрчилж, цуцалж болно.
  - 7.2. Эрх бүхий байгууллага, этгээдийн шийдвэрийг үндэслэн тодорхой үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, гишүүн байгууллага болон арилжаанд оролцогчдын системд хандах эрхийг хаах, нээх, хязгаарлах зэрэг өөрчлөлтүүдийг хийнэ.
  - 7.3. Арилжаа эхлэхээс өмнө арилжаанд оролцогчдод мэдээлэх шаардлагатай эрх бүхий байгууллагын шийдвэр, бусад мэдээллийг Service desk програмын Send announcement команд ашиглан зарлан мэдээлнэ.
  - 7.4. Энэхүү зааврын дагуу үнэт цаасны арилжааны бэлтгэл ажлыг бүрэн хангана.
8. Үнэт цаасны арилжаа эхлэхээс өмнө арилжааны *дэг хянагч* дараах бэлтгэл ажлуудыг хангана. Үүнд:
  - 8.1. Арилжаанд оролцогч МХБ-ийн арилжааны танхимаас арилжаанд оролцох тохиолдолд энгийн арилжаа эхлэхээс 10-аас доошгүй минутын өмнө гишүүн үнэт цаасны компаниудын ажилтнуудын МХБ-ийн Үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй эсэхийг шалгаж, арилжааны танхимд нэвтрүүлнэ.
  - 8.2. Арилжаа хөтлөгчийн үнэт цаасны арилжааны өмнөх бэлтгэл ажлууд хангагдсан эсэхэд хяналт тавина.
  - 8.3. Арилжааны бэлтгэл ажил хангагдаагүй, зөрчил илэрсэн бол энэ тухай арилжаа хөтлөгч болон холбогдох албадын ахлахууд /шаардлагатай тохиолдолд Үйл ажиллагааны газрын дарга/-д нэн дагуу мэдэгдэж холбогдох арга хэмжээг авна.
9. Үнэт цаасны арилжаа эхлэхээс өмнө арилжааны *програм хангамжийг хянагч* дараах бэлтгэл ажлуудыг хангана. Үүнд:
  - 9.1. Арилжааны систем тогтоосон цагт бүрэн ажиллаж эхлэхээс дуусах хүртэлх хугацааны техник хэрэгсэл, програм хангамжийн бэлэн байдлыг нэгдсэн удирдлагаар бүрэн хянасан байна.
  - 9.2. Хянах явцад аливаа зөрчил илэрвэл зөрчлийг арилгах, засварлах ажлыг шуурхай зохион байгуулна.
  - 9.3. Арилжаа эхлэхээс өмнө илэрсэн аливаа зөрчил, саатлыг засварлах боломжгүй нь тогтоогдвол энэ тухай Мэдээлэл технологийн албаны ахлах мэргэжилтэн /шаардлагатай тохиолдолд Үйл ажиллагааны газрын дарга/-д мэдэгдэж, тухайн зөрчил, саатлыг арилгах боломжит бусад арга хэмжээг нэн даруй авч шийдвэрлэнэ.
  - 9.4. Алсаас арилжаанд оролцогчдод програм хангамжтай холбоотой аливаа хүндрэл гарсан тохиолдолд тэдний хүсэлтийн дагуу шуурхай зөвлөгөө өгч, арилжааны бэлтгэлийг хангуулна.

10. Үнэт цаасны арилжаа эхлэхээс өмнө *арилжаанд оролцогч* дараах бэлтгэл ажлуудыг хангана.
  - 10.1. МХБ-ээс Trader програм хангамжид нэвтрэх зөвхөн өөрт олгосон эрхийн дагуу програмд хандаж арилжаанд оролцоно.
  - 10.2. Хариуцсан техник хэрэгсэл, програм хангамжийн бэлэн байдлыг шалгаж, саатал илэрвэл алсаас арилжаанд оролцогч нь өөрийн байгууллагын програм хангамжийн ажилтнаар саатлыг нэн даруй арилгуулна, зайлшгүй тохиолдолд МХБ-ийн програм хангамжийн хянагчтай холбогдон зөвлөгөө авч болно, харин арилжааны танхимаас арилжаанд оролцогч нь арилжааны дэг хянагч болон програм хангамжийг хянагч нарт мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авахуулна.
  - 10.3. Арилжаа хөтлөгчөөс арилжаанд оролцогчдод мэдээлэл илгээсэн эсэхийг Trader програмын Announcements цонх ашиглан шалгана.
  - 10.4. МХБ-тэй байгуулсан "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г баримтлан арилжааны бэлтгэл ажлыг бүрэн хангана.
  - 10.5. Арилжааны танхимаас арилжаанд оролцогч нь энгийн арилжаа эхлэхээс 10-аас доошгүй минутын өмнө арилжааны танхимд ирсэн байна.
  - 10.6. Арилжааны танхимаас арилжаанд оролцогчид нь ажил хэрэгч хувцаслаж, арилжааны дэг болон ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө.

#### **Гурав. Үнэт цаасны арилжааг зохион байгуулах**

11. Үнэт цаасны арилжааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд *арилжаа хөтлөгч* дараах дэгээр зохион байгуулна:
  - 11.1. Тухайн өдрийн арилжааг нээх, хаах үед цанг 1 удаа цохино.
  - 11.2. Арилжааны явцад програм хангамжийн болон бусад аливаа саатал гарвал арилжааны дэг хянагч болон програм хангамжийг хянагчид нэн даруй мэдэгдэнэ.
  - 11.3. Арилжаа хөтлөгчийн зүгээс тухайн өдрийн арилжааны явцад хийгдсэн аливаа хэлцлийг хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн гэж үзвэл Хяналтын албанд тус хэлцлийг хянуулахаар хандаж болно. Хяналтын алба уг хэлцлийг шалгаж тухайн өдрийн сэжиг бүхий хэлцэл шалгасан тайланд тусгана.
  - 11.4. Арилжааны явцад арилжаанд оролцогчдод зайлшгүй мэдээлэх шаардлагатай эрх бүхий байгууллагын шийдвэр, бусад мэдээллийг Service desk програмын Send announcement команд ашиглан зарлан мэдээлнэ.
12. Арилжааны *дэг хянагч* арилжааны явцад дараах үүргийг гүйцэтгэнэ:
  - 12.1. Арилжааны танхимын дотоод дэг, хэвийн үйл ажиллагааг хянана.
  - 12.2. Арилжаанд оролцогчдын ирцийн бүртгэл хөтлөнө.
  - 12.3. Үнэт цаасны арилжаанд оролцогч нь холбогдох дүрэм журмыг зөрчих нөхцөл бүрдсэн тохиолдолд Хяналтын албаны ахлах мэргэжилтэн /шаардлагатай тохиолдолд Үйл ажиллагааны газрын дарга/-д мэдэгдэж

- зөрчлийг нэн даруй арилгах талаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд зохих арга хэмжээ авна.
- 12.4. Арилжааны явцад техникийн болон програм хангамжийн саатал гарвал энэ тухай тэмдэглэлд тодорхой тусгана.
13. Үнэт цаасны арилжааны явцад арилжааны програм хангамжийг хянагч дараах үүргийг гүйцэтгэнэ:
- 13.1. Арилжааны танхимын техникийн болон програм хангамжийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавина.
  - 13.2. Арилжааны явцад техникийн болон програм хангамжийн саатал гарвал саатлыг нэн даруй арилгах, залруулах арга хэмжээг авна.
  - 13.3. Гарсан саатлыг арилгах, залруулах боломжгүй бол энэ тухай Хяналт болон Мэдээлэл технологийн албаны ахлах мэргэжилтнүүд /шаардлагатай тохиолдолд Үйл ажиллагааны газрын дарга/-д нэн даруй мэдэгдэж, холбогдох бусад арга хэмжээг авахуулна.
  - 13.4. Саатал, зөрчлийг арилгасан даруйд арилжааны дэг хянагчид нэн даруй мэдэгдэж, саатлын талаар тэмдэглэлд тодорхой тусгана.
14. Арилжаанд оролцогч арилжааны явцад дараах дэгийг баримтлан үнэт цаасны арилжаанд оролцоно:
- 14.1. Арилжааны нэг суудлын эрхэд 2-оос илүүгүй арилжаанд оролцогч оролцоно.
  - 14.2. Арилжааны явцад асууж тодруулах зайлшгүй шаардлагатай зүйл гарвал, арилжаа хөтлөгч болон дэг хянагчид хандана.
  - 14.3. Арилжаа хөтлөгч, арилжааны дэг хянагч нарын тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлнэ.
  - 14.4. Арилжаа хөтлөгчөөс арилжаанд оролцогчдод мэдээлэл илгээсэн эсэхийг Trader програмын Announcements цонх ашиглан шалгана.
  - 14.5. Харилцагчаас өгсөн захиалгын нөхцлүүдийг сайтар шалган системд оруулна. Арилжаанд оролцогчийн анхаарал болгоомжгүйн улмаас захиалгын санд буруу нөхцлөөр орсон захиалгын дагуу хэлцэл хийгдсэн тохиолдолд тухайн хэлцлийг буцаах боломжгүй.
  - 14.6. Техникийн болон програм хангамжийн саатал гарсан үед алсаас арилжаанд оролцогч нь өөрийн байгууллагын програм хангамжийн ажилтнаар нэн даруй арилгуулна, зайлшгүй тохиолдолд МХБ-ийн програм хангамжийн хянагчтай холбогдон зөвлөгөө авч болно, харин арилжааны танхимаас арилжаанд оролцогч нь арилжааны дэг хянагч болон програм хангамжийг хянагч нарт мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авахуулна.
  - 14.7. Техникийн болон програм хангамжийн саатал гарсан тухай арилжааны дэг хянагчид тухайн цаг үед нь мэдэгдээгүйгээс шалтгаалан гарсан гомдлыг хүлээн авахгүй.
  - 14.8. Алсаас арилжаанд оролцогчид нь арилжааны явцад богино хугацаанд засварлах боломжгүй техник, програм хангамжийн болон цахилгааны саатал гарсан тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр МХБ-ийн арилжааны танхимаас арилжаанд оролцож болно.

14.9. Арилжааны танхимаас арилжаанд оролцогч нь арилжааны танхимаас түр болон бүр гарах тохиолдолд арилжааны дэг хянагчид мэдэгдэнэ.

**Дөрөв. Үнэт цаасны арилжааны дараах үйл ажиллагаа**

15. Арилжааны танхимаас арилжаанд оролцогч нь арилжаа дуусмагц дилерийн даалгаврыг дэг хянагчид хураалгана.
16. Алсаас арилжаанд оролцогч нь дилерийн даалгаврыг тухайн өдрийн 15 цагт МХБ-ийн Хяналтын албанд цахим хэлбэрээр [surveillance@mse.mn](mailto:surveillance@mse.mn) хаягаар ирүүлнэ.
17. Арилжаа хөтлөгч арилжааны тайлан мэдээллийг тухайн өдрийн 16 цагаас өмнө гаргаж, Үйл ажиллагааны газрын дарга, дэд захирал болон гүйцэтгэх захиралд танилцуулна.
18. Тендер саналын арилжаа явагдсан тохиолдолд тухайн өдрийн арилжааны тайланг дараа өдрийн арилжаанаас өмнө энэхүү зааврын 17 дугаар зүйлд заасан албан тушаалтнуудад танилцуулна.
19. Арилжааны дэг хянагч ирцийн болон сэжиг бүхий хэлцэл шалгасан тайланг тухайн өдрийн 16 цагаас өмнө гаргаж, Хяналтын албаны ахлах мэргэжилтнээр хянуулан, Үйл ажиллагааны газрын дарга, дэд захирал болон гүйцэтгэх захиралд танилцуулна.

**Тав. Анхдагч зах зээлийн арилжаа**

20. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тогтоосон цагийн хуваарийн дагуу явагдана.
21. Анхдагч зах зээлийн арилжаа нь зөвхөн МХБ-ийн арилжааны танхимд явагдана.
22. Анхдагч зах зээлийн арилжааны бэлтгэл ажил, зохион байгуулалт болон арилжааны дараах үйл ажиллагааны явцад арилжаа хөтлөгч, дэг хянагч, програм хангамжийн хянагч нар нь энэхүү зааварт тусгагдсан үүргийг мөн адил гүйцэтгэнэ.
23. Анхдагч зах зээлийн арилжаанд оролцогч нь МХБ-ээс үнэт цаасны арилжаанд оролцох эрх авсан этгээд байна.
24. Анхдагч зах зээлийн арилжааны тайлан мэдээг тухайн үнэт цаасыг анхдагч зах зээлд нийлүүлж дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.

**Зургаа. Хориглох үйл ажиллагаа**

25. Арилжаа хөтлөгчид хориглох үйл ажиллагаа:
  - 25.1. Арилжааны явцад ажлын байрыг эзгүй орхих,
  - 25.2. Албан ёсны арга хэмжээний үеэр байгууллагын удирдлагууд болон зочид нэвтрэхээс бусад тохиолдолд өөрийн ажлын байранд зөвшөөрөлгүй хүн нэвтрүүлэх.
26. Арилжааны дэг болон програм хангамжийн хянагч нарт хориглох үйл ажиллагаа:

- 26.1. Арилжааны явцад арилжааны танхимд зөвшөөрөлгүй хүн нэвтрүүлэх,
  - 26.2. Арилжааны явцад ажлын бус шаардлагаар арилжаанд оролцогчтой ярилцах, тэдэнд саад учруулах, арилжаанд оролцогчдын дэлгэцийг харах.
27. Арилжаанд оролцогчдод хориглох үйл ажиллагаа:
- 27.1. Арилжаа хөтлөгч арилжааны цанг цохиж, арилжаа нээгдснээс хойш арилжааны танхимд нэвтрэх,
  - 27.2. Арилжаа хөтлөгч, арилжааны дэг хянагчийн тавьсан зүй ёсны шаардлагыг эсэргүүцэх,
  - 27.3. Арилжааны явцад бусдад саад учруулах, арилжааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, бусадтай зүйн зохисгүй харьцах, бусад арилжаанд оролцогчийн дэлгэцийг харах, арилжаа хянагчид мэдэгдэлгүйгээр ажлын байрыг орхиж явах,
  - 27.4. Арилжааны танхимын техник хэрэгсэл, програм хангамжийг арилжаа хийхээс бусад зорилгоор ашиглах,
  - 27.5. Арилжааны програмд нэвтрэх өөрийн эрхийг МХБ-ээс арилжаанд оролцох эрх аваагүй этгээдэд шилжүүлэх,
  - 27.6. Холбогдох этгээдийн зөвшөөрөлгүйгээр арилжааны бус цагаар биржид нэвтрэх.

#### **Долоо. Хүлээлгэх хариуцлага**

28. Энэхүү зааврыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд МХБ-ийн "Хөдөлмөрийн дотоод журам", "Хяналт шалгалтын журам", "Гишүүнчлэлийн журам" болон "МХБ-ийн гишүүдийн ажилчдын ёс зүйн дүрэм"-ийн холбогдох заалтуудыг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.